



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/58

Есөнбулаг

┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** ┐


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам" А/254 дүгээр тушаалын хавсралтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Есөнбулаг, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Г.Болдбаатар	(Байгаль, орчин аялал жуулчалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Д.Гаадамба	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)
	Ш.Батзүсэм	(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсон)
Нарийн бичиг:	Ж.Бодьгэрэл	(Есөнбулаг сумын иргэн)
	Б.Эрхбаяр	(Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай, шуурхай зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг үнэлгээний хороо (Г.Болдбаатар)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

